



**МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ**

2013 оны 10 сарын 09 өдөр

Дугаар 373

Улаанбаатар хот

**Төслийн удирдах хорооны
бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай**

Монгол Улсын Засгийн газар, Азийн хөгжлийн банк хооронд “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-3, 4” төслийг хэрэгжүүлэх буцалтгүй тусlamжийн болон хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээр, “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5” төслийг хэрэгжүүлэх хөнгөлөлттэй зээлийн хэлэлцээр, Сангийн сайдын 2011 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Засгийн газрын гадаад зээл, тусlamжийн хөрөнгөөр санхүүжих төслийг хэрэгжүүлэхэд баримтлах журам”-ыг үндэслэн ТУШААХ нь:

1.“Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-3”, “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-4”, “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5” төслийн хэрэгжилтийг хангах үүрэг бүхий Удирдах хорооны бүрэлдэхүүнийг хавсралтаар шинэчлэн баталсугай.


2. Удирдах хорооны үйл ажиллагааг мэргэжил, арга зүйн удирдамжаар хангаж ажиллахыг Эрүүл мэндийн дэд сайд, Удирдах хорооны дарга /Ж.Амарсанаа/-д даалгасугай.


3. Эрүүл мэндийн сайдын 2012 оны 394 тоот тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан Удирдах хорооны ажиллах журмын 3.8 дугаарт “Эрүүл мэндийн салбарын хөгжил хөтөлбөр-5” төслийн бичиг баримтад тодорхойлсон зорилго, зорилт болон Аюулгүй цус сэлбэлт, Эмнэлгийн хог хаягдлын менежмент, Эмнэлгийн эрүүл ахуй, эмнэлгээс шалтгаалах халдвараас сэргийлэх ба халдварт хяналтыг сайжруулах чиглэлээр боловсруулсан бодлогын зөвлөмжийг хэлэлцэн шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд Эрүүл мэндийн сайдын зөвлөлд танилцуулан шийдвэрлүүлэх” гэсэн заалтыг нэмэлтээр оруулсугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 394 дүгээр тушаалын нэгдүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Н.УДВАЛ





53

УДИРДАХ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

- Дарга: Эрүүл мэндийн дэд сайд
- Нарийн бичгийн дарга: "ЭМСХХ-3,4,5" төслийн удирдагч
- Гишүүд:
ЭМЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга
ЭМЯ-ны Бодлого төлөвлөлтийн газрын дарга
ЭМЯ-ны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
ЭМЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга
ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн хэлтсийн дарга
ЭМЯ-ны Гадаад хамтын ажиллагааны хэлтсийн дарга
ЭМЯ-ны Эм, эмнэлгийн хэрэгслийн хэлтсийн дарга
ЭМЯ-ны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга
ЭЗХЯ-ны Эдийн засгийн хамтын ажиллагаа, зээл, тусlamжийн бодлогын газрын дарга /зөвшилцсөнөөр/
Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга /зөвшилцсөнөөр/
БОНХЯ-ны Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга /зөвшилцсөнөөр/
Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын яамны Нийгмийн хамгааллын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга /зөвшилцсөнөөр/
Нийгмийн даатгалын ерөнхий газрын дэргэдэх Эрүүл мэндийн даатгалын газрын дарга /зөвшилцсөнөөр/



Цус сэлбэлт судлалын үндэсний төвийн ерөнхий захирал

Халдварт өвчин судлалын үндэсний төвийн ерөнхий захирал

Нийслэлийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч дарга /зөвшилцсөнөөр/

Нийслэлийн Засаг даргын Барилга, хот байгуулалт, дэд бүтцийн асуудал хариуцсан орлогч дарга /зөвшилцсөнөөр/

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга /зөвшилцсөнөөр/

Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгүүдийн үндэсний холбооны гүйцэтгэх захирал /зөвшилцсөнөөр/

Монголын эмнэлгүүдийн холбооны захирал /зөвшилцсөнөөр/

Монголын эм зүйн байгууллагуудын нэгдсэн “Эм” холбооны захирал /зөвшилцсөнөөр/